



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/318

Мөрөн сум

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 9.37.106 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалтууд, аймгийн ИТХ-ын ээлжит IX хуралдааны 2018 оны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Авъяас” сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрны барилгын угсралтын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний эхний санхүүжилтэд шаардлагатай 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь зураг төслийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд)-д зөвшөөрсүгэй.

2. 320 хүүхдийн барилгын зураг төслийг хүлээн авах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

d/zahiramj

01112869